



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 02 сарын 23 өдөр

Дугаар 1/77

Хэрлэн сум

Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчлэн шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.1, 26.1.2, аймгийн Онцгой комиссын 2017 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол түмний уламжлалт Сар шинийн баярыг тохиолдуулан төв суурин газрын халаалтын найдвартай ажиллагааг бүрэн хангуулах зорилгоор тус аймгийн Засаг даргын Тамгын газар, Бэрх тосгоны захирагчийн алба, “Хэнтий ус” ХК, “Цагаан цахир уул” ХХК, “Суно” ХХК, “Нямодо трейд” ХХК, “Ерөөл төгс” ХХК, “Оч манлай” ХХК, Баянхутаг сумын “Дорнын нүүрс” ХХК-ий Хавтгайн нүүрсний уурхай, Батноров сумын Бэрх тосгоны “Бэрх Уул” ХК-ийг 2017 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн 09:00 цагаас 2017 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 10:00 цаг хүртэл гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсүгэй.

2. Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан төвлөрсөн уурын зуухны хэвийн ажиллагааг бүрэн хангаж, нүүрсний татан авалт, нөөцийг бүрдүүлж ажиллахыг “Хэнтий ус” ХХК, “Цагаан цахир уул” ХХК, “Суно” ХХК, “Нямодо трейд” ХХК, “Ерөөл төгс” ХХК, “Оч манлай” ХХК-ий дарга, захирал нарт үүрэг болгосугай.

3. Өндөржүүлсэн бэлэн байдлын үед төвлөрсөн уурын зуухнуудын хэвийн ажиллагааг бүрэн хангахуйц хэрэгцээт нүүрсийг нийлүүлж ажиллахыг Бэрх тосгоны “Бэрх Уул” ХК-ий захирал Б.Мэндсайхан, нүүрсний уурхайн дарга А.Эрдэнэхуяг, “Дорнын нүүрс” ХХК-ий Хавтгайн нүүрсний уурхайн дарга Г.Өлзийдоо нарт даалгасугай.

4. Баяр амралтын өдөр, өндөржүүлсэн бэлэн байдлын үед хариуцлагатай жижүүр томилон холбогдох үүрэг даалгавраар хангаж, байгууллагынхаа халаалтын хэвийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг аж ахуйн нэгж байгууллага, агентлагийн дарга нарт үүрэг болгосугай.


01 450

2//.

5. Төвлөрсөн уурын зуухнуудын нүүрсний татан авалт, нөөцийн бүрдүүлэлт, "Бэрх Уул" ХХК-ны Чандганы уурхай, "Дорнын нүүрс" ХХК-ны Хавтгай нүүрсний уурхайн нүүрс олголтонд хяналт тавьж, мэдээ мэдээллээр хангаж ажиллахыг Хөгжлийн бодлогын хэлтсийн дарга Э.Мөнх-Эрдэнэ, Мэргэжлийн хяналтын газрын дарга Б.Сүнгээ нарт үүрэг болгосугай.

6. Энэхүү захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Засаг даргын орлогч Г.Хэрлэнчулуунд даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА